

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр

№ТУЗТ 02/2020

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох,
Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод
байгуулах болон шаардах эрх үүссэн тухай

Компанийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 53 дугаар зүйл, 54 дүгээр зүйл, 55 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.7 дахь хэсэг, 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, 81 дүгээр зүйлийн 81.2, 81.4 дэх хэсэг, “Хар хорум пропертийс” ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлаар “Хар хорум пропертийс ХК”-д “Эрдэнэс солюшинс” ХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах болон Компанийн зарласан энгийн хувьцаанаас 1 (нэг) ширхэг нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'751'262 (арван таван сая долоон зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран хоёр) ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд эргэлтэд хувьцаа нэмж гаргахаар шийдвэрлэсэн, Хөрөнгийн үнэлгээний “Мөнх-Оргил трейд” ХХК-ийн 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн №03-01 тоот “Бизнесийн үнэлгээний тайлан”, Монголын хөрөнгийн биржийн Компанийн хувьцааны арилжааны хаалтын ханшаас өмнөх зургаан сарын жигнэсэн дундаж ханш болон тус Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авах шаардах эрх үүссэн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Монгол Улсын иргэн Төмөрболд овогтой Золбоог сонгоусгай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг дараах бүрэлдхүүнтэйгээр байгуулсугай:
 - 2.1 Аудитын хорооны дарга: П.Нарантунгалаг
гишүүн: С. Энхжаргал
Э. Цэндсүрэн
 - 2.2 Цалин, урамшууллын хорооны дарга: Т. Золбоо
гишүүн: С. Энхжаргал
Б. Энхзориг
 - 2.3 Нэр дэвшүүлэх хорооны дарга: Б.Энхзориг
гишүүн: Ц. Хүдэрмөнх
П.Нарантунгалаг
3. Хувьцаа эзэмшигчдийн өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнийг 120 (нэг зуун хорь) төгрөгөөр тогтооусгай.
4. Хувьцаа эзэмшигчдийн өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдсан 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр байхаар тогтоосугай.
5. Энэ шийдвэрийн 3 дахь хэсэгт заасан шаардах эрхийг хэрэгжүүлж эхлэх огноог Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдсан 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөр,

хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноог 2020 оны 02 дугаар сарын 29-ний өдөр буюу хуанлийн 36 (гучин зургаан) хоног байхаар тогтоосугай.

- 6 Хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардлагыг Компани дээр бичгээр хүлээн авах бөгөөд хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш хуанлийн 36 (гучин зургаан) хоногийн дотор шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтийг бичгээр ирүүлээгүй тохиолдолд Компанийн хувьцаа эзэмшигчээр хэвээр үлдэх саналтай гэж үзсүгэй.
- 7 “Хувьцаагаа компанид эргүүлэн худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх журам”-ыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
- 8 “Компанийн шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх зар”-ыг энэхүү тогтоолын Хоёрдугаар хавсралтаар баталсугай.
- 9 Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Т.Золбоо)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/



“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАХ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын Компаний тухай хуулийн 53, 54, 87, 88 дугаар зүйл, Хар хорум пропертийс ХК-ийн (цаашид “Компани” гэх) дүрмийн холбогдох заалтад тус тус заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хуралд оролцоогүй, эсхүл эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхийг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай журам нь Компанийн тухай хууль, Компаний засаглалын кодекс болон холбогдох бусад хууль тогтоомжийн актаас бүрдэнэ.

ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШААРДАХ ЭРХ, БҮРТГЭЛ

- 2.1. Компаний тухай хууль, Компаний дүрэм болон энэ журамд заасан дараах асуудлаар шийдвэр гаргасан хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон төлөөлөгчөөрөө дамжуулан санал хураалтад оролцоогүй, эсхүл хувьцаа нэмж гаргах шийдвэрийн эсрэг саналтай байсан Компаний хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрх үүснэ.
Үүнд:
 - 2.1.1. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх замаар компани өөрчлөн байгуулах;
 - 2.1.2. Компани энэ журамд заасан хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн;
 - 2.1.3. Компаний дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан.
- 2.2. Энэ журмын 2.1.2-т заасан хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл гэдэгт дараах хэлцлүүд хамаарна. Үүнд:
 - 2.2.1. Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл өөр хоорондоо шууд холбоотой хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;
 - 2.2.2. Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт;
- 2.3. Хувьцаагаа компаниас худалдаж авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж худалдаж авах шаардлагаа бичгээр эсхүл өөрийн брокер, дилерийн компаниараа дамжуулан гаргана.
- 2.4. Хувьцаа эзэмшигч нь энэ журмын 2.3-т заасан шаардлагыг Компаний хувьцаа эзэмшигчдэд хурлын зар хүргэх журмын дагуу шаардах эрх үүссэн тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлснээс хойш хуанлийн 36 өдрийн дотор гаргана.
- 2.5. Компаний хувьцаа эзэмшигчдийн өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон өдөр байна.

- 2.6. Эрх бүхий хувьцаа эзэмшигч нь шаардах эрхийг хэрэгжүүлэх журамтай холбоотой зөвлөгөө, зааварчилгааг Компаниас авах эрхтэй.



ГУРАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Компани нь энэ журмын 2.1-т заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авах шаардах эрх үүсгэсэн шийдвэр компаниас гаргаснаас хойш, түүнийг хэрэгжүүлэх журмын талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.
- 3.2. Компани нь хувьцаа эзэмшигчдэд шаардах эрх үүссэн тухай хэрхэн мэдэгдэх, шаардах эрхийг хэрэгжүүлэх хугацаа, худалдан авах үнэ, нөхцөл зэргийг Төлөөлөн удирдах зөвлөл эсхүл түүнээс эрх олгосон Гүйцэтгэх захирал тогтооно.
- 3.3. Компани дараах үндэслэлээр хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдах тухай шаардлагад татгалзсан хариу хүргүүлэх эрхтэй. Үүнд:
- 3.3.1. Хувьцаагаа эргүүлэн худалдах тухай шаардлага нь Компанийн тухай хууль болон энэ журамд заасан шаардлагыг хангаагүй;
- 3.3.2. Хувьцаа эзэмшигч төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээс илүү үнээр хувьцаагаа худалдахыг санал болгосон;
- 3.3.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаас өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахаас татгалзсан шийдвэр гаргасан.
- 3.4. Компани дор дурдсан нөхцөлд хувьцаагаа эргүүлэн худалдаж авах хувьцаа эзэмшигчдийн шаардлагад татгалзсан хариу өгөх эрхтэй ба энэ талаарх шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргана. Үүнд:
- 3.4.1. Компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авснаар төлбөрийн чадваргүй болох нөхцөл байдал үүссэн;
- 3.4.2. Компанийн сүүлийн балансад тусгагдсан өөрийн хөрөнгийн хэмжээ нь компанийн дүрэмд заасан хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн хэмжээнээс багассан.
- 3.5. Компани нь хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн худалдаж авах эсхүл худалдаж авахаас татгалзсан тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргах ба хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор гаргаж, шаардлага хүргүүлсэн хувьцаа эзэмшигчдэд хариуг хүргүүлнэ.
- 3.6. Энэ журмын 3.5-д заасны дагуу Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдол шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлэх мэдэгдэлд татгалзах үндэслэлийг тодорхой заасан байна.

ДӨРӨВ. ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- 4.1. Шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь тус журмын 2.4-т заасан хугацаанд хувьцаагаа худалдах хүсэлтээ энэ журамын дагуу Компанид ирүүлснээр шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлт баталгаажна.
- 4.2. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд хувьцааг худалдан авах арилжааг зохион байгуулахад зөвлөх компанитай гэрээ байгуулан ажиллаж болно.
- 4.3. Компани нь шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гарган холбогдох мэдэгдлийг арилжаа зохион байгуулахад оролцох эрх бүхий байгууллагад мэдэгдлийг хүргэнэ.
- 4.4. Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох зөвшөөрөл, шийдвэр гарсан даруйд компани эсхүл түүнтэй гэрээ байгуулсан зөвлөх компани нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон өдөр Монголын хөрөнгийн биржийн арилжааны цагаар шаардах эрхийг хэрэгжүүлэх арилжааг зохион байгуулна.
- 4.5. Шаардах эрхээ хэрэгжүүлэх санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчид нь өөрийн үйлчлүүлдэг Брокер, дилерийн компаниар дамжуулан хувьцаа худалдах захиалгаа энэхүү журмын 2.4-д заасан өдрөөс өмнө өгсөн байна.

- 4.6. Шаардах эрхээ хэрэгжүүлэх санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчид нь энэхүү журмын 2.4-д заасан өдрөөс ажлын 1 хоногийн өмнө Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь өөрийн төлбөр тооцооны дансанд худалдах хувьцаа болон холбогдох шимтгэлийг бүрэн байршуулсан байна.



ТАВ. БУСАД

- 5.1. Хувьцаа эзэмшигч нь энэ журамд заасны дагуу шаардах эрх үүссэнээс хойш ажлын 36 хоногт багтаан хувьцааг эргүүлэн худалдаж авах тухай шаардлагыг гаргаагүй нөхцөлд тухайн хувьцаа эзэмшигч шаардах эрхээсээ татгалзсан гэж үзнэ.
- 5.2. Энэ журмын хэрэгжилттэй холбогдон гарсан гомдлыг Компани нь зохих журмын дагуу хүлээн авч шийдвэрлэнэ.

Хар хорум пропертийс" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2020 оны 01 сарын 28-ний өдрийн
ээлжит бус хурлын № ТУЗ 02/2020 тоот
шийдвэрийн Хоёрдугаар хавсралт



"ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Хар хорум пропертийс" ХК нь 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар "Хар хорум пропертийс" ХК-д "Эрдэнэс сольюшинс" ХХК-ийг нэгтгэх замаар компанийг өөрчлөн байгуулах, хаалттай хүрээнд 15'751'262 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган эзэмшүүлэх, хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх, компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг шийдвэрүүдийг гаргасан.

Гаргасан шийдвэрүүдийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүссэнийг үүгээр мэдэгдэж байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас шийдвэр гарсан огноо: 2020 оны 01-р сарын 24-ний өдөр

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: 2020 оны 02-р сарын 29-ний өдрийг дуустал

Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ: 120 төгрөг /хувьцааны арилжааны хаалтын ханшаас сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш/

Шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй бол "Хар хорум пропертийс" ХК болон "Эс Жи Капитал ҮЦК" ХК-д хандана уу.

Шаардах эрх хэрэгжүүлэгч "Хар хорум пропертийс" ХК: УБ, ЧД, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 7/2, Денвер оффис, холбогдох утас: 11-70119588

Андеррайтер "Эс Жи Капитал ҮЦК" ХХК: УБ, ЧД, 3-р хороо, Жуулчны гудамж, 44, Арт хаус, 6-р давхар, холбогдох утас: 11-70112191, 99922517